



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 508

Улаанбаатар хот

“МИАТ” Төрийн өмчит хувьцаат компаниас
гадаадын хөрөнгийн бирж дээр гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 1.3, 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “МИАТ” Төрийн өмчит хувьцаат компанийн гадаадын үнэт цаасны зах зээл дээр нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 1,000 /нэг мянга/ америк долларын нэрлэсэн үнэтэй, 20,000 ширхэг, 5 жилийн хугацаатай, нийт 20,000,000 /хорин сая/ америк долларын үнийн дүн бүхий ерийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т зөвшөөрсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 4.1-д заасны дагуу гадаадын үнэт цаасны зах зээл дээр байршуулсан тухай болон арилжаалагдаж буй үйл явцын талаар хагас жил тутамд Хороонд ирүүлж, тайлагнаж байхыг “МИАТ” Төрийн өмчит хувьцаат компани /Г.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ
ТОГТООЛ